



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.16 № 2/20 ЧАТ-САТ/2014/80/СМА-ТМУЗ

Хохирлыг нөхөн төлүүлэх тухай

Төрийн Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Үндэсний Аудитын газрын захиалгаар "Од бүртгэл Аудит" ХХК нь Буянт Ухаа спортын ордны 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нягтлан бодогч С.Золзаяа нь Монголын авто замчдын холбооноос арга хэмжээ зохион байгуулсны төлбөрийг бэлнээр хүлээн авсан боловч байгууллагын дансад 9,0 сая төгрөгийг дутуу тушааж, төсвийн байгууллагад хохирол учруулсан байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12 "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 тоот тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

Аудитаар илэрсэн 9,0 сая төгрөгийг нягтлан бодогч С.Золзаяагаар төлүүлж, Буянт Ухаа спортын ордны Төрийн сан банк дахь 900035034 тоот дансад 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор төвлөрүүлэхийг Буянт Ухаа спортын ордны дарга С.Мөнхсүх, нягтлан бодогч Б.Жамцгэрэл нарт хариуцуулсугай.

АКТЫГ

ТОГТООСОН:

АХЛАХ АУДИТОР:

/Д.ГАНБИЛЭГ/

УХА0122

ЗӨВШӨӨРСӨН:

БУЯНТ УХАА СПОРТЫН ОРДНЫ
ДАРГА

/С.МӨНХСҮХ/

НЯ- БО 55290
УЖА0050

/Б.ЖАМЦГЭРЭЛ/